

**Монгол Улс**  
**НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн**  
**зөвлөлдөх уулзалт**  
**2017 оны 8-р сарын 31**

*Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл [ibaatarkhuu@worldbank.org](mailto:ibaatarkhuu@worldbank.org) у-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.*

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 8 дугаар сарын 31-нд 15 иргэний нийгмийн байгууллагуудтай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p><b>Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</b></p>	<p><b><u>Сорилт ба улс орны нөхцөл байдлын дүн шинжилгээ</u></b></p> <p><b>Ерөнхий тойм ба ядуурлыг бууруулах:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийг хангах чухал хүчин зүйл байсан боловч эдийн засаг уул уурхайн салбараас хэт хамааралтай байна.</li> <li>• Ардчиллын тогтолцоонд аливаа хүчирхийлэлгүй тайван шилжиж чадсан ч ардчилал нийгэмд үр өгөөжөө өгч чадаагүй; улс төрийн тогтворгүй байдал давамгайлсан.</li> <li>• Хүн амын боловсролтой дундаж давхарга ба харьцангуй өгөөмөр нийгмийн үйлчилгээ нь нийгмийг нэн ядуурлаас аварсан.</li> <li>• Тэгш бус байдал нэмэгдсэн бөгөөд зарим тооцоогоор ядуурлын түвшин 60%-д хүрсэн.</li> <li>• Эрүүл мэндийн үйлчилгээ хэт төвлөрсөн гэх мэт нийгмийн үйлчилгээ сул, хангалтгүй байгаа нь иргэдийг ядуурал руу хөтөлж, сөргөөр нөлөөлж байна.</li> <li>• Дээд боловсролтой иргэдийн ажилгүйдлийн түвшин өндөр.</li> <li>• Ардчилал нийгэмд үр ашгаа өгөөгүй. Социализмын үед ядуурал байгаагүй, харин өдгөө тэгш бус байдал нэмэгдэн, ядуурал бодит амьдралд буурахгүй байна.</li> <li>• Зарим оролцогчид Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжээд удаагүй байгаа, суралцаж яваа гэдгийг тодотгов. Ядуурлын хэмжээ буурч байгаа бөгөөд зарим хэсгийн амьжиргаа дээшлээд,</li> </ul>

заримых нь хэвэндээ үлдсэн нь ядуурал нэмэгдсэн мэт сэтгэгдэл төрүүлж байна.

**Засаглал ба хариуцлага хүлээх чадвар:**

- Иргэдийн өмнө хүлээх улс төрийн хариуцлага дутмаг.
- Иргэний нийгмийн байгууллагууд сул учраас нийгмийг амжилттай төлөөлж чаддаггүй. Мэргэшсэн ТББ-ууд цөөн. ИНБ-ууд гол төлөв эмэгтэй удирдлагатай, санхүүжилт байдаггүй.
- Баян чинээлэг хүмүүс л өөрсдийн эрх ашгийн төлөө үйлчлэх хуулийг боловсруулж баталдаг шударга бус явдал нэмэгдсээр байна.
- Улсын салбарын гүйцэтгэл муу, улсын салбарт чадавх бэхжүүлэх шаардлагатай. өмнөх чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа нь тогтвортой байж чадаагүй; төрийн албан хаагчид чадавхгүй, төрийн албаны халаа сэлгээ маш их .
- Иргэдийн оролцооны талаар зүйл заалт бүхий бараг 105 хууль байдаг боловч бодит амьдралд бараг хэрэгждэггүй.
- Үр дүнтэй төлөвлөж чаддаггүй.
- Улс орны хөгжилд улс төр хэтэрхий их нөлөөлдөг.
- Стандартжуулалтыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ маш бага.
- Хүн амын иргэнийн боловсрол маш доогуур, олон нийт төр, засгийн газартайгаа бүтээлчээр, үр дүнтэй зөвлөлддөггүй, үзэл бодол, дуу хоолойгоо сонсгож чаддаггүй.
- Хүний эрхийг огоорч, шүүх нь жирийн иргэдээ хамгаалж чадахгүй болсон, хууль эрх зүйн тогтолцоонд тэгш бус байдал үүссэн.
- Улсын төсвийн зарцуулалтын хяналт сул, засгийн газар нь хариуцлага хүлээх чадваргүй.
- Төрийн зарим үйлчилгээг иргэний нийгмийн байгууллагуудад аутсорсинг хийж шилжүүлэх шаардлагатай.

**Төрөлжүүлэх:**

- Уламжлалт бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй, амьжиргаа алдагдаж байна. Малчид уул уурхайгаас болж бэлчээр, усаа алдаж, эрхээрээ хохирч байна.
- Сүүлийн жилүүдэд шинээр барьж байгуулж хөгжүүлсэн томоохон үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр байхгүй.
- Арилжааны банкуудын үйл ажиллагаа сул, цаашид хөгжүүлэх шаардлагатай.

**Бусад:**

- Улсын салбар хэмжээ, цар хүрээний хувьд тэлсэн. Авилгалын асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай.
- Бүх ТББ-ууд нийгэмд сайн үйлчилж чадахгүй байна. ТББ-уудын санхүүжилтын эх үүсвэр донор, хандивлагч байгууллагуудын тусламжаас хамааралтай байна.

	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэстэн, ястан, баялаг, жөндөр гэх мэт зүйлсээр ялгаварлах үзэл газар авч байна. Энэ нь сүүлийн сонгуулийн үеэр нэг нэгнээ Монгол цустай, эрлийз гэх мэт ялгаварлан үзэж байснаас харагдсан.</li> </ul>
<p><b>ДБГ-ын стратеги ба түншлэлийн баримт бичигт өгсөн санал</b></p>	<p><b>Засаглал ба хариуцлага хүлээх чадвар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төр засаглал ба тогтвортой байдлын асуудлаа цэгцлэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд ДБГ цаашид дэмжлэг үзүүлэх шаардлагагүй. Зарим оролцогчид, Засгийн газар ДБ-с өгч буй зөвлөмжийг сонсдог учир ДБГ бодлогын сайн зөвлөмж өгч, бусад орны сайн туршлагаас хуваалцах хэрэгтэй гэв.</li> <li>• Нийгмийн эгэх хариуцлагын механизмыг бэхжүүлэх шаардлагатай; иргэний нийгмийн байгууллагууд нийгмийн хариуцлагын хөтөлбөр, үйл ажиллагаанд оролцох нь илүү үр дүнтэй байдаг нь нотлогдсон.</li> <li>• Улс төрийн намуудын удирдлага хүчтэй, шударга байх ёстой, улс төрийн намууд хууль бус санхүүжилтын эх үүсвэрээс хараат байх явдлыг бууруулахын тулд улс төрийн намуудыг улсын төсвөөс санхүүжүүлэх зохицуулалт хийх.</li> <li>• Нэн тэргүүнд иргэний боловсролд анхаарч сургалтын цөм хөтөлбөрт агуулгыг тусгах шаардлагатай.</li> <li>• Төр иргэд, олон нийттэй харилцах харилцаагаа бэхжүүлэх шаардлагатай.</li> <li>• Нийгмийн салбарын бодлого, дүн шинжилгээг эдийн засгийн үзүүлэлттэй харьцуулахад дутуу дулимаг боловсруулсан.</li> <li>• Төсвийн тогтвортой байдлыг дэмжих.</li> </ul> <p><b>Төрөлжүүлэх:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Уул уурхай бус, хөдөө аж ахуй, орон нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг нэн тэргүүнд хөгжүүлэх</li> </ul> <p><b>Хүн капитал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинэ сургууль барих гэх мэт боловсролын үйлчилгээ үзүүлэх дэд бүтцийг бэхжүүлэхэд анхаарах бус багш бэлтгэх боловсролын тогтолцоог шинэчлэх шаардлагатай, багш нарын шинэ үеийг сургаж бэлтгэх нь зүйтэй. Өнөөдөр сурлага муутай хүүхдүүд л багш бэлтгэх сургуульд элсэн суралцаж байгаа нь тулгамдсан асуудал болж байна.</li> <li>• Академик мэдлэг боловсрол харьцангуй сайн байсан хэдий ч ёс суртахуун, ухамсрын боловсрол алдагдан, шинэ залуу үе ёс суртахууны боловсролгүй болоход нөлөөлж байна.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөөгийн хөгжил, тогтвортой амьжиргаа чанартай сургуулиас шууд хамааралтай байдаг. Хүн амын дотоод шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэх гол хүчин зүйл нь сайн боловсрол бөгөөд хөдөөгийн сургуулиудын дотуур байрыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.</li> <li>• Төсвийн хүндрэлтэй, хязгаарлагдмал байдлын улмаас нийгмийн эрүүл мэндийн боловсрол маш доогуур.</li> <li>• Нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгох шаардлагатай.</li> </ul> <p><b>Хувийн хэвшил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хувийн хэвшлийн хөгжил нь эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр мөн.</li> <li>• Хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх.</li> <li>• Хувийн хэвшлийн салбарт компани, аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг дээшлүүлэх замаар хүний эрхийг хүндлэн дээдлэх.</li> <li>• Хувийн хэвшлийн салбарт хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлага буюу медиа менежмент хамгийн муу хөгжсөн. Чухал мэдээллийг олон нийтэд хүргэхэд томоохон үүрэг гүйцэтгэдэг учраас орон нутгийн, жижиг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дэмжлэг үзүүлэх.</li> <li>• Эрчим хүчний хараат бус байдлыг дээшлүүлэхийн тулд сэргээгдэх эрчим хүч, нарын эрчим хүчийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.</li> <li>• Татвар, банкны салбарыг хөгжүүлэх шаардлагатай.</li> </ul> <p><b>Иргэний нийгэм:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэний нийгмийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, чадавхыг нь бэхжүүлэх шаардлагатай.</li> <li>• Гишүүд эсвэл нийгэмд үйлчилдэг бүх байгууллагуудыг ялгамжаатай тогтоох зэргээр ТББ-ын тухай хуулинд өөрчлөлт оруулах; хувийн хэвшил энэ салбарт илүү хувь нэмэр оруулахыг дэмжсэн татварын бодлого зохицуулалтхийх шаардлагатай. Жишээ нь ИНБ-ууд, төр, засгийн газрын хооронд бүтээлчээр зөвлөлддөг чадавх, туршлага байхгүй байна. Амьдрах ухаан, чадавх бэхжүүлэх чиглэлээр арга хэмжээ авах нь зүйтэй.</li> <li>• Зээлийн төслүүдийн мониторинг, хяналт, үнэлгээг гуравдагч тал/иргэний нийгмээр хийлгэх боломжтой.</li> </ul> <p><b>Байгаль орчныг хамгаалах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчны хамгааллыг төрөл бүрийн нийгэм-эдийн засгийн асуудалтай хутгахгүй байх нь зүйтэй. Байгаль орчны доройтлын асуудлыг яаралтай шийдвэрлэх.</li> <li>• Нэн тэргүүнд тэнцвэртэй, нэгдсэн цогц хөгжлийг хангах нь зүйтэй.</li> </ul>
<b>ДБГ-ын оролцоо, зөвлөлдөх</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэгжүүлсэн төслүүдийн тогтвортой байдалд онцгой анхаарах (төсөл хаагдсаны дараа).</li> </ul>

<p><b>уулзалтуудын талаарх санал</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын салбарт сайн хийгдэж буй судалгаа шинжилгээний ажлуудыг үргэлжлүүлэх, нотолгоонд суурилсан бодлого боловсруулж үнэлэх.</li> <li>• Зээлийн төслийн зохицуулалт, хяналт мониторингийг бэхжүүлэх.</li> <li>• Шинэ төсөл боловсруулахдаа улс, орон нутгийн өвөрмөц онцлогийг харгалзан тусгах. Зарим оролцогчид ДБ-ны дэмжлэгтэй сайжруулсан зуухны төсөл орон нутгийн нөхцөл байдалд сайн нийцээгүй байснаас үр дүн муу байсан гэж үзэж байв.</li> <li>• Төслийн төлөвлөлтийн үе шатанд нягт нарийн үнэлгээ хийх.</li> <li>• Усан цахилгаан станц, нүүрсний цахилгаан станц гэх мэт байгаль орчинд ээлгүй төслүүдийг дэмжихгүй байх, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих. Энэ салбарыг хөгжүүлэх боловсон хүчний нөөц дутмаг гэдгийг анхаарах. Төсөл хэрэгжихээс өмнө өргөн хүрээний хэлэлцүүлэг, байгаль орчны үнэлгээг хийх.</li> <li>• Нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт таниулга сурталчилгааны энгийн механизм ашиглан ДБГ-ын төслүүдийн талаарх Монгол хэлээр бэлтгэсэн мэдээллийг олон нийтэд таниулах үйл ажиллагааг сайжруулах.</li> </ul>
<p><b>Бусад</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Нэг оролцогч ДБГ-ын зөвлөгөөг Засгийн газар сайн сонсож, дагаж мөрддөг тул өнөөгийн нийгэм эдийн засгийн асуудлууд ДБГ-ын зүгээс өгсөн зөвлөмж, зөвлөгөөнөөс үүдэлтэй, ДБГ улс орныг сүйрүүлсэн, ядуурал, тэгш бус байдал шилжилтийн өмнөх үеийнхээс доройтсон гэв. Засгийн газар, уул уурхай, хувийн хэвшил нийлж ард түмнээс “хулгайлж” байна.</li> <li>• Зарим оролцогчид ИНБ-ууд илүү хөгжин, нийгэмд илүү их үүрэг гүйцэтгэн, Засгийн газрын хариуцлагыг сайжруулахаар ажиллах ёстой гэв.</li> <li>• Сэргээгдэх эрчим хүч, мэдээлэл харилцаа холбооны технологийг хөгжүүлэх зэрэг (ДБ-ны) дэд бүтцийн төслүүд амжилттай хэрэгжиж, нэн ялангуяа хөдөө орон нутгийн шүтэлцээ, холбоог сайжруулахад түлхэц үзүүлсэн.</li> </ul>

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

– Төрийн удирдлага/шинэтгэл	55.56% 5
– Эрүүл мэнд	55.56% 5
–	55.56%

Боловсрол	5	
–	44.44%	
Эрх тэгш боломжоор хангах	4	
–	44.44%	
Авлигатай тэмцэх	4	
–	33.33%	
Байгалийн нөөцийн удирдлага	3	
–	33.33%	
Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	3	
–	22.22%	
Нийгмийн хамгаалал	2	
–	22.22%	
Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	2	
–	22.22%	
Хүнсний аюулгүй байдал	2	
–	22.22%	
Хөдөөгийн хөгжил	2	
–	11.11%	
Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	1	
–	11.11%	
Хувийн хэвшлийг хөгжүүлэх	1	
–	11.11%	
Санхүүгийн зах зээл	1	
–	11.11%	
Гадаадын хөрөнгө оруулалт	1	
–	11.11%	
Эдийн засгийн өсөлт	1	
–	0.00%	
Зам, тээвэр	0	
–	0.00%	
Худалдаа, экспорт	0	
–	0.00%	
Хотын хөгжил	0	
–	0.00%	
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	0	
–	0.00%	
Эрчим хүч	0	
–	0.00%	
Ус, ариун цэврийн байгууламж	0	
–	0.00%	
Гамшгийн эрсдэлийн удирдлага	0	

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

– Хүний хөгжлийг дэмжих	66.67% 6
– Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	55.56% 5
– Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	33.33% 3
– Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	33.33% 3
– Бүгд чухал	22.22% 2
– Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	11.11% 1